



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2022. 04. 14 № 17

Г Асуулга тавих тухай Г

“Аудитын сэдэв батлах тухай” Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 05 дугаар тогтоолын дагуу Үндэсний аудитын газараас Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтэд гүйцэтгэлийн аудит хийсэн бөгөөд тайланг Нийгмийн бодлогын байнгын хорооны 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанаар сонслоо.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсэгт зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл болон өнчин эмийн жагсаалтад орсон эмийн үнийн дээд хязгаарыг Засгийн газар тогтоохоор заасан боловч аудитын дүгнэлтэд үнийн дээд хязгаарыг санхүүжүүлэгч байгууллага тогтоож байна гэжээ.

Түүнчлэн Эрүүл мэндийн даатгалын сангаас хамгийн өндөр дүнгээр үнийн хөнгөлөлт олгосон зарим бүлгийн эмийн үнэд судалгаа хийхэд зах зээлд худалдаалагдаж буй үнэ нь импортолсон үнээс 10.0-82.0 хувиар өндөр байгаа тухай болон хамгийн өндөр санхүүжилт авч буй артерийн даралт бууруулах 6 эмийн үнийг медиан үнэтэй харьцуулахад 5.4-15.6 дахин өндөр байна гэсэн дүгнэлт гарчээ.

Эрүүл мэндийн даатгалын сангаас 2016-2021 онд жороор олгох эмийн хөнгөлөлтөд нийт 226.5 тэрбум төгрөг олгосноос артерийн даралт бууруулах бүлгийн эмд 66.9 тэрбум төгрөг, хепатитийн В, С вирусийн эсрэг эмд 36.3 тэрбум, халдварын эсрэг эмд 12.3 тэрбум төгрөгийг тус тус олгосон байна. Эдгээр гурван бүлгийн эмд олгосон үнийн хөнгөлөлт нь нийт олгосон санхүүжилтийн 51.0 хувийг эзэлж байна гэжээ.

Мөн Эрүүл мэндийн даатгалын сангаас зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт болон эмчилгээний зааварт ороогүй, олон улсад үр дүнгийн нотолгоо муутай гэж үздэг, нэмэлт бүтээгдэхүүн гэх ангиллын эмийг хөнгөлөлттэй үнээр олгож, хөрөнгө зарцуулсан нь зайлшгүй шаардлагатай нэн чухал хэрэгцээтэй бусад эм болон эмчилгээг шаардлагатай өвчтөнд хүргэх боломжийг хаасан байна.

Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогод “Уламжлалт анагаах ухаанд тулгуурлаж, байгалийн гаралтай түүхий эд ашиглаж үйлдвэрлэсэн, аюулгүй, идэвхтэй, чанартай эм хэрэглэхийг дэмжих” зорилт дэвшүүлсэн хэдий ч уламжлалт эмийн дотоодын үйлдвэрлэлийг дэмжих тогтвортой, үр дунд чиглэсэн бодлого хэрэгжүүлээгүйгээс уламжлалт эмийн түүхий эд импортоос хараат хэвээр байна.

Уламжлалт эм үйлдвэрлэгч нь байгалийн ургамал, газрын нөхөн сэргээлтийг хийх, нөхөн сэргээлтийн төлбөрийг урьдчилж байршуулах, байгалийн нөөцийн экологи-эдийн засгийн үнэлгээг үндэслэн ойн санд учирсан хохирлыг гурав дахин, ургамлын аймагт учирсан хохирлыг тав дахин, газарт учирсан хохирлыг гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр төлөхөөр байгаа нь уламжлалт эм үйлдвэрлэгчид дарамт болох, зөвшөөрөлгүйгээр түүхий эд бэлтгэх эрсдэл үүсгэж байгаа тухай дурджаэ.

Үндэсний аудитын газраас ирүүлсэн тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт, мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийнхээ хүрээнд хүн ам, эрүүл мэндийн байгууллагыг эмчилгээний өндөр идэвхтэй, аюулгүй, чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүнээр тасралтгүй, жигд хүртээмжтэй хангахтай холбоотой дараах асуулгыг Танд хандан тавьж байна:

1. Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, өнчин эмийн үнийн дээд хязгаарыг хэрхэн тогтоож байгаа тухай болон эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар авч байгаа арга хэмжээний тухай;

2. Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн үнийг бууруулах үүднээс нэгдсэн худалдан авалт болон олон улсын байгууллагаар дамжуулан хийх худалдан авалтыг өргөтгөх, худалдан авах эмийн нэр төрлийн сонголтыг сайжруулах талаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, цаашид авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа үйл ажиллагааны тухай;

3. Уламжлалт эмийн үйлдвэрлэлийг дэмжих, түүхий эдийг дотоодоос бэлтгэх, тарималжуулах талаар төрөөс баримталж байгаа бодлого, үзүүлж байгаа дэмжлэг, эрх зүйн зохицуулалтыг оновчтой болгох талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар;

4. Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй үнээр олгож буй эмийн нэр төрөл, үйлчилгээ, санхүүжилтийн хэмжээ жил бүр өсөн нэмэгдэж байгаа хэдий ч үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай зарим эмийн нэр төрлийн сонголт буруу, оновчгүй, тогтоосон үнийн дээд хязгаар, хөнгөлж байгаа хэмжээ нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн хувисаа төлөх төлбөрийг хэмжээг дорвитой бууруулж чадахгүй байгаа тул холбогдох хууль тогтоомж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл болон Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар зэрэг болно.

Энэхүү асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасан хугацаанд бичгээр ирүүлж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулах бэлтгэлийг хангаж ажиллахыг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Ц.ТУВААН

2022000027